



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/03

Хажуу шинэ үс

Орон нутгийн хөгжлийн сангийн
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын (орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам батлах тухай) 1 дүгээр хавсралтын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ түүний ач холбогдлыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх аргазүйн зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Сарангэрэл (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Э.Лайжинханд (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Гишүүд:

Б.Хорол (Газрын даамал)

Н.Ганбат (Санхүү албаны дарга)

Д.Мандахцацрал (Байгаль орчны улсын байцаагч)

Б.Мөнхтөгөлдөр (1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Валя (Иргэний төлөөлөл)

2. Иргэдэд төсвийн тухай хууль тогтоомжийг сурталчлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудад олон нийтийн оролцоог жигд хангаж зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2022 оны 01 дугаар сарын 26-ний өдрийн А/07 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

482301003